

		Баримт бичгийн дугаар: 3-Ж-011	
Баталсан: Төлөөлөн удирдах зөвлөл		Баталсан огноо: 2023/06/20	Хуудасны тоо: 6
Баримт бичгийг хариуцагч: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга		Танилцах албан тушаалтнууд: ББСБ-н хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага	

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэл, аудитын хорооны ажиллах журам Эх хувь

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Өөрчлөлтийн бүртгэлийг энэхүү баримт бичигт өөрчлөлт оруулах хүсэлтэд үндэслэн хөтлөх ба энэ тохиолдолд өөрчлөлтийг эрх бүхий албан тушаалтан баталсан байна.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

АГУУЛГА	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН	3
ГУРАВ. ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	3
ДӨРӨВ. ХОРООНЫ ХУРАЛ	3
ТАВ. ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ЭРХ	4
ЗУРГАА. ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	4
ДОЛОО. АЖЛЫН ТАЙЛАН	6
НАЙМ. БУСАД	6

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 7.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо (“Эрсдэл, аудитын хороо” гэх) нь Компанийн нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдал болон бүртгэлийн баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хөндлөнгийн аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-ийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 7.2. Эрсдэл, аудитын хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах, хууль тогтоомжид заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.

ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1. Эрсдэл, аудитын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ нь Эрсдэл, аудитын хорооны гишүүд болон даргыг томилно.
- 2.2. Эрсдэл, аудитын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүд байх ба Эрсдэл, аудитын хорооны бүх гишүүд санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, туршлагатай байна.
- 2.3. Эрсдэл, аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байх ба Компанийн хөндлөнгийн аудитортай аливаа холбоогүй, сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй байна.
- 2.4. Эрсдэл, аудитын хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд томилогдох хүртэл ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 2.5. Эрсдэл, аудитын хороо нь ТУЗ-д ажлаа танилцуулж, тайлагнана.

ГУРАВ. ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

- 3.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Эрсдэл, аудитын хорооны нарийн бичгийн дарга байна.
- 3.2. Эрсдэл, аудитын хорооны нарийн бичгийн дарга нь хороог ажиллах нөхцөл боломжоор хангаж, хорооны хурлыг зохион байгуулах ажлыг хариуцна.

ДӨРӨВ. ХОРООНЫ ХУРАЛ

- 4.1. Эрсдэл, аудитын хороо нь жилд 4 хүртэл удаа, хамгийн цөөндөө жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан гарахаас өмнө 2 удаа хуралдсан байна.
- 4.2. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг Эрсдэл, аудитын хорооноос жил бүр батална.

- 4.3. Хурлын зарыг 21 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, тайланг гишүүдэд урьдчилан хүргүүлэх бөгөөд хуралд биеэр болон цахим хэрэгсэл ашиглан оролцож болно.
- 4.4. Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн болон дотоод аудиторуудын саналаар хурлыг зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд 4.3 дахь заалт хамаарахгүй.
- 4.5. Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах зорилгоор Компанийн Гүйцэтгэх захирал, ажилтнууд нь гагцхүү тус хорооны хүсэлтээр хуралд оролцоно. Бусад тохиолдолд Эрсдэл, аудитын хорооны хуралд гишүүдээс бусад этгээд оролцох эрхгүй.
- 4.6. Хурал нь гишүүдийн 2/3 оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 4.7. Хурлаас гарах бүх шийдвэрийг олонхын саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Эрсдэл, аудитын хорооны дарга хагалах эрхтэй.

ТАВ. ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ЭРХ

- 5.1. Эрсдэл, аудитын хороо нь дараах асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах, шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Үүнд:
 - 5.1.1. Санхүүгийн тайлангийн явцыг хянах;
 - 5.1.2. Албан үүргийнхээ дагуу шалгалт явуулах;
 - 5.1.3. Гүйцэтгэх удирдлага болон Компанийн ажилтнуудаас Эрсдэл, аудитын хорооны нарийн бичгийн даргаар дамжуулан мэдээлэл шаардах (Эрсдэл, аудитын хорооноос гаргасан шаардлагын дагуу Компанийн бүх ажилчид хамтран ажиллах үүрэгтэй);
 - 5.1.4. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар компанийн гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар, заавар зөвлөмж өгөх;
 - 5.1.5. Шаардлагатай тохиолдолд Компанийн зардлаар гаднын хуулийн болон бусад хараат бус мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг авах, холбогдох мэдлэг, туршлагатай хөндлөнгийн байгууллагын оролцуулах;
 - 5.1.6. Компанийн эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангах, хянах, шаардлагатай арга хэмжээ авах зорилгоор эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжид үүрэг даалгавар өгөх;
 - 5.1.7. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах.

ЗУРГАА. ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 6.1. Эрсдэл, аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
 - 6.1.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх;
 - 6.1.2. Санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, онцгой анхаарал хандуулж хянах;
 - 6.1.3. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

- 6.1.4. Аудитын шалгалтаар шаардлагатай болсон томоохон залруулга;
 - 6.1.5. Бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим;
 - 6.1.6. НББ-ийн стандарт, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бусад холбогдох хуулийг баримтлан ажилласан байдал;
 - 6.1.7. Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдал.
 - 6.1.8. ТУЗ-ийн тодорхойлсон бусад асуудал.
- 6.2. Дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр дараах үйл ажиллагаанд хяналт тавина. Үүнд:
- 6.2.1. Компанийн эрсдэлийг удирдах бодлого, стратегийг тодорхойлох;
 - 6.2.2. Луйвар залиланг илрүүлэх, түүний талаар мэдээлэл өгөх тухай компанийн журмыг шалгаж, санхүүгийн тайлан, санхүүгийн хяналт болон бусад асуудалтай холбоотой зөрчлийн талаар ажилтнууд өөрт аюулгүйгээр санал гомдол гаргах боломжийг хангасан байхыг шалган баталгаажуулах;
 - 6.2.3. Компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлага болон санхүүгийн тайлагналын бодлого, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх тоймыг хянан шалгах;
 - 6.2.4. Дотоод хяналт, санхүүгийн тайлан, эрсдэлийн удирдлага болон санхүүгийн тайлагналын бодлого, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх тоймыг хянан шалгах;
 - 6.2.5. Компанийн санхүүгийн дотоод хяналтын зөв зохистой байдлыг хянах;
 - 6.2.6. Компанийн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын талаар жилийн тайланд оруулсан тайлбарыг хянах;
 - 6.2.7. Санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, шалгах зорилго удирдлагаас тогтоосон системийн далайц, үр дүнг үнэлж дүгнэх;
 - 6.2.8. Дотоод, гадаад хяналтын тогтолцоогоор болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хяналтын явцад илэрсэн аливаа зөрчил, дутагдал болон тэдгээрийг арилгах арга хэмжээний талаар ТУЗ-д байнга тайлагнах.
- 6.3. Санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудит, түүний бие даасан байдлыг хянан шалгах. Үүнд:
- 6.3.1. Хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах;
 - 6.3.2. ТУЗ-өөр батлуулахаас өмнө, хөндлөнгийн аудитын үйлчилгээний цар хүрээ, үнэ хөлсийг хянан шалгаж, аудитын шалгалт чанарын өндөр түвшинд хийгдэхэд хангалттай хэмжээнд байгааг баталгаажуулах;
 - 6.3.3. Аудитын агуулга, цар хүрээний талаар хөндлөнгийн аудитортой зөвшилцөх;
 - 6.3.4. Хөндлөнгийн аудитортой хамтран хийгдсэн ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх.
- 6.4. Эрсдэл, аудитын хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нар нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Компанийн зүгээс хүлээлгэн өгсөн, танилцуулсан, эсвэл шалгалтаар илрүүлсэн бүхий л төрлийн мэдээ, мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, гуравдагч этгээдэд задруулах, аливаа хэлбэрээр дамжуулахгүй байх үүрэгтэй.

6.5. Энэ Дүрмийн 6.4-т заасан этгээдүүд Компанийн нууц мэдээллийг задруулсны улмаас хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулах ба ТУЗ-ийн шийдвэрээр чөлөөлөх хүртэл арга хэмжээг авна.

ДОЛОО. АЖЛЫН ТАЙЛАН

7.1. Хорооны нарийн бичгийн дарга нь Эрсдэл, аудитын хорооны хурлын батлагдсан тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүд, дотоод, гадаад аудит болон гүйцэтгэх удирдлагад хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн чухал санал, дүгнэлт, тохиролцсон асуудлыг багтаасан байна.

7.2. Эрсдэл, аудитын хороо нь албан үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлагын дагуу хийсэн ажлаа жил бүр ТУЗ-д тайлагнаж, Компанийн жилийн ажлын тайлан болон Компанийн цахим хуудсанд тавигдах тайланд дүгнэлт бэлтгэнэ. Уг дүгнэлтэд дараах зүйлсийг оруулна.

7.2.1. Эрсдэл, аудитын хорооны гүйцэтгэх үүрэг болон явуулсан үйл ажиллагааны тойм;

7.2.2. Тайлант хугацаанд ажилласан Эрсдэл, аудитын хорооны гишүүдийн бүтэц, бүрэлдэхүүн;

7.2.3. Эрсдэл, аудитын хороо хурлын ирц, хуралдсан давтамж.

НАЙМ. БУСАД

8.1. Хороо нь энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д саналаа гаргаж болно.

8.2. Энэхүү Дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн дараагийн өөрчлөлт орох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ